

Инженер-механикийн тэнхим нь хуучнаар Цэргийн инженерийн сургуулийн авто инженерийн, цэргийн инженерийн, хуягт танкийн, инженерийн суурь онолын тэнхимүүдийн гүйцэтгэдэг байсан үүргүүдийг цаашид үргэлжлүүлэн сургалт судалгааны вйл ажиллагаагаа явуулж байна.

2015 оны 07 сард БХИС-ийн бүтэц зохион байгуулалтанд оорчлолт орж Аюулгүй байдлын сургуулийн Инженер механикийн тэнхим нэртэйгээр оргожин зохион байгуулагдан авто инженерийн, хүнд машин механизмын, цэргийн инженерийн хавсарга хотолборвудээр торол мэргэжлийн инженерийн бакалавр зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэж байна.

Тэнхимийн эрхэм зорилго нь инженерийн чиглэлээр бакалавр, магистрын сургалт, судалгаа явуулах, дээд боловсролын стандарт хангасан Батлан хамгаалах болон бусад салбарт ажиллах мэдлэг чадвар дадлагатай, иргэний ондор соёлтой, хорвох чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Одоо тэнхимийн дарга нэг, багшлах бүрэлдэхвүн арван долоо, лабораторийн эрхлэгч нэг бүрэлдэхвүнтэйгээр авто инженер, барилга замын машины ашиглалт, хүнд машин механизмийн ашиглалт, уул уурхайн машины ашиглалт, барилгын, усны эрэл хайгуул, ус хангалтын, авто замын барилгын инженер мэргэжлээр оюутнуудыг сургаж бэлтгэж байна.

Сургалтын вйл ажиллагаанд инженерийн техник хэрэгсэл, хуягт танкийн мульти медиа танхим болон тренажёр, авто машины зохион байгуулалт, цахилгаан тоноглолын дадлагын байруудыг ашиглаж байна.

Манай тэнхимд хэрэгжиж байгаа торол мэргэжлийн хотолборвуд нь зөвсөгт хүчин, монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэргүүлэх салбар болох уул уурхайн, барилга вйлдвэрлэл, авто замын салбаруудад мэргэжилтэн боловсон хүчин бэлтгэж байгаагаараа онцлог юм.

Тус тэнхим нь сургалтын вйл ажиллагаагаараа БХЯ болон ЗХЖШ-ын харьяа газар

хэлтэсүүд, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль болон “Механик инженерийн мэргэжилтэн” бэлтгэдэг сургуулиуд , Авто Тээврийн Үндэсний Тов, Замын Цагдаагийн Газар, Гэрээт авто сервис, Засвар вйлчилгээний товүүдтэй хамтран ажиллаж байна.

Цаашид 2015-2016 оны хичээлийн жилд сургалтын орчинг сайжруулах зорилгоор оюутнуудын дадлага лабораторийг үр дүнтэй явуулах сургалтын хэрэглэгдэхвнийг сайжруулж, патентжуулах, мон хий шингэний лабораторийг байгуулах, тэнхимдээ мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийн номын фондтой болох зорилт тавин ажиллаж байна.

Тэнхимийн багшлах бүрэлдэхвн



